

**NEAR Холбооны Байгаль орчны хорооны тайлан
(2022 он)**



Япон улс, Тояама муж
(2023 оны 2 сар)

Дараалал

I 2022 оны төслийн хэрэгжилтийн байдал.....	3
i Санаачилсан төсөл	3
ii Төсөлд оролцсон байдал	3
iii Төсөл бүрийн хэрэгжилтийн байдал.....	4
II 2023 оны төсөл төсөлд оролцох хүсэлтээ илэрхийлсэн орон нутаг.....	20
i Санаачилсан төсөл	20
ii Санаачилсан төслийн агуулга	22
iii Төсөлд оролцох хүсэлтэй орон нутаг	37
III Хорооны дараагийн зохицуулагчийн талаар орон нутгуудын дунд явуулсан санал асуулгын дүн	38
IV Байгаль орчны үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө	39

I 2022 оны төслийн хэрэгжилтийн байдал

i Санаачилсан төсөл

No.	Төслийн нэр	Санаачилсан
No.1	Зүүн хойд Азийн хүүхэд залуучуудыг байгаль орчны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр	Чүнчоннам муж, Тояама муж
No.2	Хог хаягдлын гаралтыг багасгах төсөл	Тояама муж
No.3	Зүүн хойд Азийн байгаль орчны сэдэвт зурагт хуудасны уралдаан	Хабаровск хязгаар
No.4	Далайн эргийн амьд биетийн судалгаа	Тояама муж
No.5	Нялцгай биетийг ашигласан цэнхэр нүүрстөрөгчийн талаарх хүүхдийн байгаль орчны танин мэдэхүйн хөтөлбөр	Чүнчоннам муж
No.6	"Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа selfie зургаар" гэрэл зургийн уралдаан	Томск муж
No.7	Зүүн хойд Азийн амьд биетийн улирлын судалгаа	Тояама муж

ii Төсөлд оролцсон байдал (⊙ : Төслийг санаачлагч орон нутаг, ○ : Төсөлд оролцох хүсэлт илэрхийлсэн орон нутаг)

Орон нутаг* ¹		Төсөл	Байгаль орчны манлайлагч	Далайн хог хаягдлын судалгаа ²	Зурагт хуудасны уралдаан	Далайн амьд биетийн судалгаа	Цэнхэр нүүрстөрөгч	Гэрэл зургийн уралдаан	Амьд биетийн улирлын судалгаа
Хятад	Шаньси муж		○	—	—	—	—	○	—
	Ляонин муж		—	—	—	—	—	—	—
Япон	Ям агага муж		-	○ S	-	-	-	—	—
	Тояама муж		○	⊙	○	⊙	○	○	⊙
	Ишикава муж		-	○ S	-	○	-	—	—
	Фүкүй муж		-	○ S	-	○	-	—	—
	Киото муж		-	○ S	-	-	-	—	—
	Хёго муж		-	○ S	-	-	-	—	—
	Тоттори муж		-	○ S	-	○	-	—	—
	Шиманэ муж		-	○ S	-	-	-	—	—
	Ямагүчи муж		-	○ S	-	-	-	—	—
	Сага муж		-	○ S	-	-	-	—	—
	Нагасаки муж		-	○ S	-	-	-	—	—
Солонгос	Ганвон муж		-	○ S	-	-	-	—	—
	Чүнчоннам муж		⊙	○ S	○	-	⊙	—	○

	Гёнсаннам муж	-	○ S	-	-	-	-	-
Монгол	Дархан-Уул аймаг	○	-	-	-	-	-	-
	Дундговь аймаг	○	-	○	-	-	-	-
Орос	Алтайн хязгаар	○	-	-	-	-	-	-
	Приморийн хязгаар	○	○ S	○	○	○	○	○
	Хабаровск хязгаар	○	○	◎	○	○	-	○
	Амур муж	-	-	○	-	-	○	-
	Эрхүү муж	-	-	-	-	-	○	-
	Сахалин муж	-	-	-	-	-	○	-
	Томск муж	○	-	○	-	-	◎	-
	Кемеров муж	-	-	-	-	-	○	-
Оролцсон орон нутаг		5 улс, 9 орон нутаг	3 улс, 16 орон нутаг	4 улс, 7 орон нутаг	2 улс, 6 орон нутаг	3 улс, 4 орон нутаг	3 улс, 8 орон нутаг	3 улс, 4 орон нутаг

※ тэмдэглэгээ : орон нутаг, NEAR Холбооны гишүүн бус орон нутаг

※ ○ S : Хог хаягдлын судалгаа хийх, хог хаягдлаар бүтээл хийх сонголтоос зөвхөн хог хаягдлын судалгаа хийсэн

iii Төсөл бүрийн хэрэгжилтийн байдал

【No.1 Зүүн хойд Азийн хүүхэд, залуучуудыг байгаль орчны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр】Чүнчоннам муж, Тояама муж

1 Зорилго

Зүүн хойд Азийн бүсийн хүүхдүүд (дунд сурагч, ахлах сурагч-д зориулан SDGs байгаль орчны асуудлын тухай лекц тавих, санал бодол солилцох, байгаль орчныг байгаагаар нь хадгалах зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан нөхөрлөл, харилцан ойлголцлоо идэвхжүүлж, тогтвортой нийгмийг бий болгохын тулд бүс нутгийн байгаль орчныг хамгаалахад хичээн чармайлт гаргах боловсон хүчнийг бэлтгэнэ.

Зүүн хойд Азийн хүүхэд, залуучуудыг байгаль орчны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр

2 Агуулга

(1) Хугацаа

2022 оны 8 сарын 8, 9-ний өдөр

(2) Зохион байгуулсан хэлбэр

Онлайн (Zoom)

(3) гол агуулга

- Соёлын харилцаа, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны талаар илтгэл тавьсан
- Байгаль орчныг хамгаалах тухай тааврын тэмцээн зохион байгуулсан
- Санал бодол хуваалцах, гадаадын соёлтой танилцах зэргээр чөлөөтэй харилцсан.
- ”Шинээр гарч буй хог, хогны сэргээлт” сэдвээр орон нутаг бүрээр дахин боловсруулсан бүтээгдэхүүн хийсэн.
- Нийт дунд, ахлах сургуулийн 57 сурагч оролцсон.

(4) Оролцсон орон нутаг

5 улсын 9 орон нутаг

Хятад : Шаньси муж

Япон : Тояама муж

Солонгос : Чүнчоннам муж

Монгол : Дархан уул аймаг, Дундговь аймаг


Орос : Алтайн хязгаар, Приморийн хязгаар, Хабаровск хязгаар,

Томск муж

(5) Үр дүн

5 ~ 6 сард оролцогчдыг бүртгэж, 8 сард зохион байгуулсан.

(6) Арга хэмжээний зураг



Соёл заншлаа танилцуулав



Илтгэл тавьж буй нь



Чөлөөт харилцаа



дахин ашиглах бүтээл хийсэн нь



Байгаль орчны тунхаг

【No.2 Далайн хог хаягдлын гаралтыг багасгах тухай сургалт,хөтөлбөр】

Төслийг санаачилсан : Тояама муж

1. Зорилго :

Баруун хойд Номхон далайн бүсийн тэнгисийн эрэг хавийн орон нутгуудаас далайн хог хаягдлын судалгаа явуулахын зэрэгцээ далайн хог хаягдлын гаралтыг багасгах талаар сургалт зохион байгуулж, тэнгисийн эргийн бүсийн далайн хог хаягдлын асуудлын тухай ойлголтыг нэмэгдүүлж, хүүхэд залуучууд, нутгийн иргэдэд “хог хаяхгүй байх, далайн орчныг хамгаалах ухамсар” төрүүлж, өдөр тутамдаа далайд хог хаяхгүй байх дадал хэвшлийг суулгана.

2. Төслийн агуулга :

Хүүхэд залуучууд болон ард иргэдийн оролцоотойгоор далайн хог хаягдлын судалгаа, хог хаягдлыг багасгах тухай сургалт явуулсан. Мөн зарим орон нутгуудаас далайн хог хаягдал, айл өрхийн ахуйн хог хаягдлаар урлагийн бүтээл хийсэн.

Далайн хог хаягдлын судалгаа

Хугацаа : 2022 оны 6-11 сард (Намар хамгийн тохиромжтой)

Болсон газар : Хөтөлбөрт оролцогч орон нутгуудын далай, гол нуур (эх газрын гол нуур орохгүй) -ын бүс

Судалгаа явуулсан арга :

- Судалгааг тухайн хөтөлбөрт оролцогч орон нутгийн бага, дунд, ахлах сургууль, иргэдийн бага, дунд, ахлах сургуулийн сурагчид, иргэдийн байгууллагын төлөөллийн оролцоотой явуулсан.
- Судалгааны үйл ажиллагааны зэрэгцээ далайн хог хаягдлыг багасгах тухай сургалт зохион байгуулсан.
- Судалгааны дүнг Тояама муж (Олон нийтийн эрх ашгийн төлөөх сан(NPEC) байгууллага)-гаас гаргасан.
- 2021 оноос судалгааны төрөлд бичил хуванцар(5mm-ээс доош диаметртэй хуванцар хог)-ыг нэмж оруулсан. 「Далайн эргийн бичил хуванцарын судалгааны зааварчилга(Ард иргэдийн оролцоот) 」 (2021.3) -ын дагуу явуулсан)

Хөтөлбөрт оролцсон орон нутаг : 3 улс, 16 орон нутаг

Япон : Ямагата муж, Тояама муж, Ишикава муж, фүкүй муж, Киото муж, Хёго муж,
Тоттори муж, Шиманэ муж, Ямагүчи муж, Сага муж, Нагасаки муж

Солонгос : Ганвон муж, Чүнчоннам, Гёнсаннам муж

Орос : Приморийн хязгаар, Хабаровск хязгаар

Төслийн хэрэгжилт :

5-6 сард төсөлд оролцох тухай зааварчилга, судалгааны хүснэгт явуулсан.

5 сар~ Төслийн бэлтгэлийг хангаж, төслийг явуулсан.



Зураг

Далайн хог хаягдлын судалгаа (Тояама муж)



Далайн хог хаягдлын судалгаа (Нагасаки муж)

(2) Далайн хог хаягдлаар урлагийн бүтээл хийсэн

Хугацаа : Жилийн турш

Болсон газар : Төсөлд оролцогч орон нутгуудад

Төслийг явуулсан арга : Тояама мужаас хангасан зааварчилгын дагуу тухайн орон нутгуудын нөхцөлд тохируулан сургуулийн сурагч, иргэдийн оролцоотой зохион байгуулсан.

Оролцсон орон нутаг : Япон улс, Тояама муж, ОХУ, Хабаровск хязгаар

5-6 сард төсөлд оролцох тухай зааварчилгаа, судалгааны хүснэгтийг явуулсан.

5 сараас эхлэн төслийн бэлтгэлийг хангаж төслийг явуулсан.



Зураг



Далайн хог хаягдлаар урлагийн бүтээл хийсэн (Урлагийн бүтээлтэй танилцах)
(Тояама муж)

【No.3 Зүүн хойд Азийн байгаль орчны зурагт хуудасны уралдаан】

Төслийг санаачилсан : Хабаровск хязгаар

1 Зорилго

Зүүн хойд Азийн хүүхэд залуучуудын дунд байгаль орчныг хамгаалах сэдвээр зурагт хуудасны уралдаан зарлаж, шалгарсан бүтээлээр үзэсгэлэн гарган иргэдийн Зүүн хойд Азийн байгаль орчныг хамгаалах тухай ухамсрыг нэмэгдүүлнэ.

2 Агуулга

(1) Үзэсгэлэн гаргасан хугацаа

2022 оны 10~11 сар

(2) Болсон газар

Хабаровск хязгаарын Хабаровск хот (Хүүхдийн номын сан)

(3) Зохион байгуулсан арга :

- Орон нутгуудын бага, дунд, ахлах сургуулийн сурагчдын бүтээлээс шалгаруулсан.
- Орон нутгуудаас шилдэг бүтээлийг цахим системд оруулж, АЗ-ийн хэмжээтэй

хэвлэж, нэрийг нь англиар бичсэний дараа Хабаровск хязгаар руу илгээсэн.

▪ Хабаровск хязгаараас ирсэн бүтээлээр үзэсгэлэн гаргасан.

«Лавлах материал» 2021 оны зурагт хуудасны үзэсгэлэнгийн үр дүн

(4) Оролцсон орон нутаг

4 улс, 7 орон нутаг (Зурагт хуудасны тоо : 53)

- Япон : Тояама муж
- Солонгос : Чүнчоннам муж
- Монгол : Дундговь аймаг
- Орос : Приморийн хязгаар, Хабаровск хязгаар, Амур муж, Томск муж

(5) Зохион байгуулсан байдал

3-7 сард орон нутгуудаас бүтээлүүдийг хүлээн авч бүртгэн, уралдаан зохион байгуулах газар руу хуулбарыг явуулсан.

10-11 сард зохион байгуулагч орон нутгаас байгаль орчны зурагт хуудасны үзэсгэлэн гаргасан

10 сард уралдаан зохион байгуулагч орон нутаг (+NPEC) үзэсгэлэнд гаргасан бүтээлүүдийг вэбсайтад байршуулсан.

(6) Үзэсгэлэнгийн байдал





【No.4 Далайн хог хаягдлын судалгаа】 Санаачилсан орон нутаг : Тояама муж

1 Зорилго

Зүүн хойд Азийн далайн амьд биетийн олон янз байдлыг хамгаалахын тулд амьд биетийн талаарх мэдээллийг цуглуулж, гадаргууны амьд биетийн судалгааг явуулна. Уг судалгаагаар дамжуулан иргэд, хүүхдүүдийн далайн амьд биетийн талаарх сонирхлыг нэмэгдүүлж, байгаль орчныг хамгаалах, амьд биетийн олон янз байдлыг хамгаалах ухамсрыг дээшлүүлнэ.

2 Агуулга

(1) Хугацаа

2022 оны 7-9 сар

(2) Болсон газар

Судалгаанд оролцсон орон нутгийн далайн эрэг

(3) Зохион байгуулсан арга

- NPEC-аас гаргасан судалгаа явуулах зааварчилгын дагуу судалгааг явуулж, судалгааны үр дүнг хуваалцсан
- Далайн амьд биетийн талаарх мэдлэгтэй судалгааны байгууллага, NGO/NPO, салбарын мэргэжилтнүүд иргэд хүүхэд залуучуудын оролцоотой далайн амьд биетийг цуглуулж ажиглан зурагжуулан тэмдэглэсэн.

- Дэлхийн дулаарал, гадны амьд биет оршин тогтнож байгаа эсэхийг судалсан.
- Судалгааны үр дүнг (Олон нийтийн ашгийн төлөөх сан)NPEC-ээс гаргаж, вэбсайтаар мэдээлэл гаргасан

(4) Судалгаанд оролцсон орон нутаг

2 улс, 6 орон нутаг

Япон : Тояама муж, Ишикава муж, Фүкүй муж, Тоттори муж

Орос : Приморийн хязгаар, Хабаровск хязгаар

(5) Судалгааны хэрэгжилт

5 -7 сар : Судалгаанд оролцогчдыг бүртгэсэн

7-9 сар : Судалгааг явуулсан

(6) Зураг



Судалгаа явуулж буй нь (Тояама муж)

【No.5 Хүүхэд залуучуудад зориулсан хясаа ашигласан цэнхэр нүүрстөрөгчийн танин мэдэхүйн хөтөлбөр】

Санаачилсан орон нутаг : Чүнчоннам муж

1 Зорилго

Хүүхэд залуучуудад далайн эргийн орчны танин мэдэхүйн хөтөлбөрөөр дамжуулан далайн эргийн экологи, цэнхэр нүүрстөрөгч, далайн эргийн экологийг хамгаалахын ач холбогдлыг ойлгуулахад оршино.

2 Агуулга

《NEAR Холбооны хүрээнд》

(1) Хугацаа

2022 оны 6-12 сар

(2) Зохион байгуулсан газар

Хөтөлбөрт оролцсон орон нутгийн далайн эрэг

(3) Зохион байгуулсан арга

① Өсвөр нялцгай биет хясааг үржүүлж, тодорхой хэмжээнд томорсоны дараа өсөлтийг нь шалгаж (явцын эхэн, дунд, сүүлд шалгасан) нүүрстөрөгчийн хэмжээг тогтоосон.

② Хясаа нас биенд хүрэх хүртэл усан дахь нүүрстөрөгчийг биедээ хуримтлуулдаг нүүрстөрөгч тогтоох явцыг судалсан.

< Сурч мэдсэн зүйл >

- Хясааны төрөл ус цэвэршүүлдэг тухай
- Түүсэн хясааг ашиглан хоол амталгаа хийсэн
- Чулуужсан хясааны ясны музей үзэж, цэнхэр нүүрстөрөгчийн тухай ойлголттой болсон)
- Цэнхэр нүүрстөрөгчийн тухай сурах бичиг гаргаж тараасан.

(4) Хөтөлбөрт оролцсон орон нутаг : 3 улс, 4 орон нутаг

Япон : Тояама муж

Солонгос : Чүнчоннам муж

Орос : Приморийн хязгаар, Хабаровск хязгаар

(5) Төслийн хэрэгжилт

6 сар хүртэл хөтөлбөрт оролцох хүсэлтэй NEAR-ийн гишүүн орон нутгуудад хөтөлбөрийн танилцуулгыг явуулсан

7-12 сард Нялх хясааг өсгөх, нүүрстөрөгчийн тогтсон хэмжээг судлах, хүүхэд сурагчдад цэнхэр нүүрстөрөгчийн талаар байгаль орчны мэдлэг олгох сургалт явуулсан.

(6) Үйл ажиллагаа

«Чүнчоннам муж»

Мужийн ахлах сургууль(Сочон эмэгтэйчүүдийн ахлах сургууль-тай хамтран

「Сургуулийн танхимд далайн байгаль орчны тухай сургалт явуулах」 хөтөлбөрийн хүрээнд цэнхэр нүүрстөрөгчтэй холбогдох хөтөлбөрийг явуулж, байгаль орчны дугуйлангийн 22 сурагчид уур амьсгалын өөрчлөлт, далайн салбарын нүүрстөрөгчийг саармагжуулах, цэнхэр нүүрстөрөгч, далайн бохирдол, далайн чиглэлийн мэргэжил судлах зэрэг сэдвээр 5 удаагийн 10 цагийн сургалтыг ахлах сургуулийн сурагчдад зориулан зохион байгуулсан.

Хугацаа : 2022 оны 5 -9 сар хүртэл 5 удаа нийт 10 цагийн сургалт явуулсан.

Болсон газар : Сочон эмэгтэйчүүдийн ахлах сургуулийн байгаль орчны дугуйлангийн танхим

Оролцогч : Сочон эмэгтэйчүүдийн ахлах сургуулийн байгаль орчны дугуйлан (1-3-р анги) 22 сурагч, нийт давхардсан тоогоор 110 сурагч

④ Агуулга :

[1 дэх удаа] Уур амьсгалын өөрчлөлт гэж юу вэ? Уур амьсгалын өөрчлөлтийг зогсооход далайн үүрэг

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Солонгосын далайн орчин хэрхэн өөрчлөгдсөн бэ?

[2 дох удаа] Далайн нүүрстөрөгчийн төвийг сахисан цэнхэр нүүрстөрөгчийн талаар мэдье

[3 дахь удаа] Далайн цэвэр орчныг бий болгох(Далайн хог хаягдал ба бичил хуванцарын нөлөөг мэдэх)


[4 дэх удаа] Далай загасны чиглэлийн мэргэжил судлах, далай, загасны аж үйлдвэр, далайн орчны чиглэлийн гол мэргэжлийг танилцуулах

[5 дахь удаа] Сочон далайн эрэгт цэнхэр нүүрстөрөгчийн үнэ цэнийн үнэлгээ хийх
Далайн хог хаягдлыг хэрхэн боловсруулах вэ? (Нүүрстөрөгчийн төвийг сахихтай холбогдуулан дахин ашиглах арга зам)

Сургалтын арга : Онолын сургалт 1 цаг + Хэлэлцүүлэг/судалгаа 1 цаг

Бусад : Тухай үеийн төлөвлөгөөгөөр дээд тал нь 6 удаагийн сургалтаас 2 удаад нь газар дээр нь биечлэн танилцах хөтөлбөр явуулах төлөвлөгөөтэй байсан ч КОВИД-19 дахин тархсан болон сургуулийн арга хэмжээний төлөвлөгөө зэргээс шалтгаалан газар дээр нь танилцах хөтөлбөрийг явуулж чадаагүй бөгөөд танхмын сургалтыг 5 удаа, 10 цаг

явуулснаар 2022 оны төслийг хэрэгжүүлсэн.



Төсөл хөтөлбөрийн зураг (Чүнчоннам муж)

【No.6 「Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа selfie зурагт」】

Гэрэл зургийн уралдаан, Төслийн санаачлагч : Томск муж

1.Зорилго

Байгаль орчныг хамгаалах сэдэвт гэрэл зургийн уралдаанаар дамжуулж, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулж, байгаль орчныг хамгаалах соёлыг бий болгоно.

2.Агуулга

- (1) Хугацаа : 2022 оны 6 сарын 22-ны өдрөөс 12 сарын 30-ны өдрийг хүртэл
- (2) Болсон газар : ОХУ, Томск муж
- (3) Зохион байгуулсан арга

- ① Орон нутгуудаас байгаль орчныг хамгаалах тухай гэрэл зургийг

бүртгэсэн

- ② Орон нутгуудаас бүртгэж авсан зургуудыг Томск муж болон NPEC байгууллага руу явуулсан
- ③ Томск мужаас зургийг шалгаруулж, шилдэг бүтээлд шагнал олгосон
- ④ Томск мужаас шилдэг бүтээлийн шагнал, өргөмжлөл, нийт оролцогчод уралдаанд оролцсон тухай батламжийг орон нутгууд руу явуулсан
- ⑤ Орон нутгууд өргөмжлөл, шагнал батламжийг уралдаанд оролцсон хүмүүст гардуулсан
- ⑥ Томск мужаас сошиалаар шилдэг бүтээлийг танилцуулсан

(4) Оролцсон орон нутаг : 3 улс, 8 орон нутаг

Хятад : Шаньси муж

Япон : Тояама муж

Орос : Приморийн хязгаар, Амур муж, Эрхүү муж, Сахалин муж, Томск муж, Кемеров муж

※ Уралдаанд ирсэн бүтээл : 316 бүтээл
(ангилал)

ой, моджуулах үйл ажиллагаа • цэвэрлэгээ гм : 131 бүтээл

эко амьдрал (эко амьдрал) : 65 бүтээл

эко бүтээл : 120 бүтээл

(5) Төслийн хэрэгжилт

6 сарын 22-11 сарын 1 : Орон нутгууд уралдаанд ирсэн гэрэл зургийг нэгтгэж,

Томск муж эцсийн байдлаар бүртгэсэн

11 сард Томск муж бүтээлийг шалгаруулсан

12 сард Томск муж орон нутгууд руу шагнал өргөмжлөлийг илгээж сошиалд шилдэг бүтээлийг байршуулсан

(6) Уралдаанд ирсэн гэрэл зургууд

Томск муж 「Oblkomprigoda」 -ийн сошиал (VKontakte) -аас уралдааны бүтээлүүдийг үзэх боломжтой

https://vk.com/album-126197212_281076431



Уралдааны бүтээл(хэсэгчлэн авав)

【No.7 Зүүн хойд Азийн амьд биетийн улирлын судалгаа】

Санаачилсан : Тояама муж

1. Зорилго

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн талаар Зүүн хойд Азийн орон нутгууд иргэдийн түвшний хариу арга хэмжээ авахын тулд ойр хавийн гадаргууг ашиглан дэлхийн дулаарлын байдалд мониторинг хийж, иргэдийн дэлхийн дулаарлын эсрэг арга хэмжээ, эко амьдралыг бодитоор бий болгох ухамсрыг төрүүлэхийг эрэлхийлнэ.

2. Агуулга

《NEAR-ийн түвшинд》

(1) Хугацаа : Жилийн турш

(2) Болсон газар : Оролцогч орон нутгуудад

(3) Хэрэгжүүлсэн арга

- Тояама мужаас бэлтгэсэн судалгаа явуулах удирдамжийн дагуу орон нутгийн бага, дунд, ахлах ангийн сурагчид, хувийн хэвшлийн байгууллага болон бусад хүмүүсийг хамруулсан.

- Судалгааны үйл ажиллагаанд тааруулан дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөний эсрэг арга хэмжээ авах талаар суралцсан\
- Судалгааны нэгтгэлийг Тояама мужийн Номхон далайн баруун хойд бүсийн байгаль орчны хамтын ажиллагааны төв /NPEC/ гаргасан
- Тояама мужаас 2022 оноос эхлэн хэрэгжүүлсэн төслийг 2023 онд үргэлжлүүлэн гарын авлага бэлтгэн орон нутгуудтай мэдээлэл солилцон ажиллаж байна.

(4) Оролцсон орон нутаг : 3 улс, 4 орон нутаг

- Япон: Тояама муж
- Солонгос: Чүнчоннам муж
- Орос: Приморийн хязгаар, Хабаровск муж

(5) Хэрэгжүүлсэн байдал

4-5 сар Оролцогчдыг бүртгэсэн

4-12 сар Судалгаа явуулсан

~12 сар Тояама муж руу үр дүн илгээсэн

~ 3 сар Гарын авлага гаргаж, мэдээлэл солилцсон

(6) Үйл ажиллагааны байдал

《Тояама муж》

Тояама мужаас эцэг эх, хүүхдүүдийн дунд дэлхийн дулаарлын тухай сургалт явуулж, амьд биетийн улирлын судалгааг явуулсан

Хугацаа : 2022 оны 6 сарын 25-ны өдөр

Болсон газар : Тояама мужийн “Ранжу ну мури” цэцэрлэгт хүрээлэн]

Оролцсон : Тояама мужийн эцэг эх, хүүхэд бүхий 70 хүн

Зохион байгуулсан арга :

【Лекц】 Дэлхийн дулаарал ба түүнийг урьдчилан таамаглах ач холбогдол , амьд биетэд үзүүлэх нөлөө, түүний эсрэг авах арга хэмжээ, улирлын судалгаа

Хэрхэн хэрэгжүүлэх тухай лекц тавьсан

【Газар дээр нь танилцах】 Ойн замаар явж, төрөл бүрийн амьтан, ургамлын

онцлог шинж чанаруудын талаар тайлбарлах, мөн бодит зүйлсийн талаар тайлбарлаж, гарьхан цэцэг, агч модны биологи улирлын судалгаа явуулах аргын талаар бодитоор харуулж тайлбарласан Ялангуяа энэ хугацаанд гарьхан цэцэг цэцэглэж эхлэх хугацааг мэдэх болон аппликейшн ашиглан тодорхойлох аргыг танилцуулсан

⑤ Үйл ажиллагааны зураг :



Сургалт, аппликейшн суулгаж буй нь

Газар дээр нь танилцаж буй нь

«Приморийн хязгаар»

“Ургамал судлалын хүрээлэн”-гээс дэлхийн дулаарал, улирлын өөрчлөлтийн талаар мэдээлэл өгөх арга хэмжээ зохион байгуулснаар оролдогчдын ургамал, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг дээшилсэн.



«Хабаровск хязгаар»

В.П. Сысоевагийн нэрэмжит “Приамурский” амьтны хүрээлэнгийн харьяа боловсролын байгууллага болох “Хүүхэд залуучуудын байгалийн судалгааны институт” -тэй хамтран хэрэгжүүлж буй “дадлага”, “аппликейшины суулгах”, “ажиглалт хийх ургамал, шавжийг сонгох”, “ургамал ялгах арга” зэрэг сэдвүүдээр нийт 5 удаагийн сургалт зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд нийт 60 хүн оролцсон бөгөөд оролцогч бүр аппликейшн ашиглан үр дүнгээ хуваалцсан.




Дадлага, аппликейшн суулгаж буй нь



Дадлага, судалгаанд оролцогчид



Ургамлыг төрөл зүйлээр нь ялгаж буй нь



Ажиглах шавж сонгож буй нь



II 2023 оны төслийн хэрэгжилтийн байдал, төсөлд оролцох хүсэлтээ илэрхийлсэн орон нутаг

i Санаачилсан төсөл

No.	Төслийн нэр	Санаачилсан
1	Зүүн хойд Азийн хүүхэд, залуучуудыг байгаль орчин хамгаалах үйл ажиллагааны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр	Ляонин муж, Тояама муж
2	Далайн хог хаягдлыг багасгах тухай дадлага сургалт	Тояама муж
3	Зүүн хойд Азийн байгаль орчны сэдэвт зурагт хуудасны уралдаан	Шаньси муж
4	Далайн эргийн амьд биетийн судалгаа	Тояама муж
5	Хүүхэд залуучуудад зориулсан цэнхэр нүүрстөрөгч, нялцгай биет, байгаль орчны сургалт танин мэдэхүйн хөтөлбөр	Чүнчоннам муж
6	“Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа сельфи зурагт” гэрэл зургийн уралдаан	Томск муж
7	Зүүн хойд Азийн бүсийн амьд биетийн улирлын судалгаа	Тояама муж
8	【Шинэ】 Гол мөрөнд био мониторинг хийх	Приморийн хязгаар

ii Санаачилсан төслийн агуулга

Но.1 Зүүн хойд Азийн хүүхэд, залуучуудыг байгаль орчин хамгаалах үйл ажиллагааны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр

Санаачилсан : Ляонин муж, Тояама муж

1. Зорилго

Зүүн хойд Азийн хүүхэд, залуучууд (дунд, ахлах ангийн сурагчид) тогтвортой хөгжлийн зорилт /SDG/ болон байгаль орчныг хамгаалах талаар лекц тавьж, санал бодлоо солилцож, нөхөрлөл, харилцан ойлголцлыг бэхжүүлж, тогтвортой хөгжих нийгмийг бий болгохын тулд глобал өнцөгөөс байгаль орчныг хамгаалах боловсон хүчнийг бэлтгэнэ.

2. Агуулга

(1) Хугацаа : 2023 оны 8 сард

(2) Зохион байгуулагч : Ляонин муж, Тояама муж

(3) Зохион байгуулсан арга

- Япон, Солонгос, Хятад, ОХУ зэрэг орнууд жил , жилээр ээлжлэн зохион байгуулна
- Зохион байгуулагч орон нутаг төслийн агуулгыг боловсруулна
- 2023 онд Ковид-19 цар тахал үргэлжилж байгаа тул “цахим”-аар зохион байгуулагдана.
- Тогтвортой хөгжлийн зорилт /SDG/, байгаль орчноо хамгаалах үйл ажиллагаа гэх мэт сэдвээр лекц тавьж, санал бодлоо солилцоно.

(4) Жилийн төлөвлөгөө

2023 оны 5 сард төсөл хөтөлбөрт оролцогчдыг бүртгэнэ

2023 оны 8 сард төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

3.Найдаж буй үр дүн

- Тогтвортой хөгжих нийгмийг бий болгохын ач холбогдлыг ойлгож, глобал түвшинд бүсийн байгаль орчныг хамгаалахад манлайлах чадвартай хүний нөөцийг бэлтгэн хөгжүүлэх
- Төсөл хөтөлбөрөөр дамжуулан байгаль орчны асуудлаар хамтран ажиллах эв санааг бүрдүүлж, олон улсын хамтын ажиллагааг бий болгох.

4 . Орон нутгуудаас ямар байдлаар оролцох

(1) Орон нутгууд дараах байдлаар оролцоно

Орон нутгуудаас төсөлд оролцогчдыг бүртгэж, төсөл зохион байгуулах орон нутагтай холбогдож, оролцогчдын мэдээллийг өгнө

(2) Зардал

а. Зардал гарах эсэх
Зардал гарна

б Зардал гаргах

Оролцогч орон нутгууд (хурлын танхимын зардал, тоног төхөөрөмжийн зардал, харилцах зардал г.м) зардлуудыг гаргана.

Түүнчлэн төсөл хэрэгжих газар болон зөвлөгөөн зохион байгуулах зардлыг төсөл хэрэгжүүлэгч орон нутаг хариуцна.

(3) Оролцох орон нутаг

NEAR-ийн нийт гишүүн орон нутаг

【No.2 Далайн хаягдлыг багасгах дадлага, сургалт】 Санаачилсан :Тояама муж

1. Зорилго

Номхон далайн баруун хойд бүс нутгийн орон нутгууд далайн эрэг орчмыг судлах, эрэг орчмын хог хаягдлаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж, эх урсгал хэсгээс далайн эрэг хүртэлх хог, хаягдлын асуудлын талаарх ойлголтоо нэмэгдүүлж, иргэд, залуучуудыг хог хаяхгүй байхыг уриалж, далайн байгаль орчныг хамгаалах ухамсрыг төлөвшүүлж, өдөр тутамд хог хаягдлыг багасгах дадал хэвшлийг бий болгоно.

2. Агуулга

Хүүхэд залуучууд, иргэдийн оролцоотойгоор далайн хог хаягдлыг судлах, далайн хог хаягдлыг багасгах талаар дадлага сургалт явуулна. Мөн боломжтой орон нутгийн зүгээс далайн хог хаягдал, айл өрхөөс гарах хаягдлыг ашиглан урлагийн бүтээл хийнэ.

(1) Далайн хог хаягдлын судалгаа

Хугацаа :2023 оны намар

Болсон газар : Төсөлд оролцох орон нутгийн далай, гол горхи(эх газрын гол горхи орохгүй) бүхий газар

Зохион байгуулах арга : Төсөлд оролцох орон нутгуудаас бага, дунд, ахлах сургуулийн сурагч, ТББ-т оролцохыг уриалж, судалгааны үйл ажиллагаа, дадлага сургалт явуулна(Далайгүй орон нутаг цэвэрлэх үйл ажиллагаа, дадлага хийнэ)

Төслийн үр дүнг Тояама муж(NPEC)) нэгтгэнэ.

Жилийн төлөвлөгөө :

5 сар Төсөлд оролцох орон нутгуудыг бүртгэнэ

9-11 сар Судалгааг явуулна

12 сар~ Тояама мужид судалгааны үр дүнг тайлагнана

(2) Далайн хог хаягдлаар урлагийн бүтээл хийх

Хугацаа : Жилийн турш

Болох газар : Төсөлд оролцогч орон нутгуудад

Зохион байгуулах арга : Тояама мужаас гаргах зааварчилгын дагуу орон нутгууд өөрсдийн нөхцөл байдалд тааруулан, сургуулийн сурагч, нутгийн иргэдийн оролцоотой зохион байгуулна.

Жилийн төлөвлөгөө : 5 сард оролцогчдыг бүртгэнэ

7-11 сард урлагийн бүтээл хийнэ

12 сар~ Тояама мужид төслийн үр дүнг тайлагнана

3.Найдаж буй үр дүн

Хог хаяхгүй байх, иргэдийн далайн байгаль орчмыг хамгаалах ухамсрыг төлөвшүүлэхийн зэрэгцээ байгаль орчноо хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх

4. Орон нутгуудаас төсөлд ямар байдлаар оролцох

(1) Орон нутгууд дараах байдлаар оролцоно

① Хог хаягдлын судалгаа хийх

- Судалгаа хийх газрыг сонгох
- Дадлага сургалт судалгаа явуулах байгууллагыг сонгох
- Дадлага сургалт, судалгаа явуулах байгууллагад зааварчилга өгөх, сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулах
- Судалгааны үр дүнг Тояама мужид тайлагнах

② Хог хаягдлаар бүтээл хийх

- Үйл ажиллагааны төлөвлөлт, оролцогч орон нутгуудтай хамтрах, харилцаа тогтоох, оролцогчдыг бүртгэх гэх мэт
- Үйл ажиллагаанд хэрэглэгдэх хаягдал, багаж хэрэгсэл бусад материалыг бэлтгэх
- Иргэдийн оролцоонд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах, үр дүнг нэгтгэн тайлагнах

(2) Гарах зардал

Дараах байдлаар зардал гаргана

① Хог хаягдлын судалгааны зардал

- Шаардлагатай зардлыг оролцогч талууд хариуцна.
- Тояама мужаас судалгаанд хэрэглэгдэх метр, хямсаа, хэмжигч болон бусад тоног төхөөрөмж , бензин, гэрэл зургийн зардлуудыг хариуцна.

② Хог хаягдлаар бүтээл хийх зардал

- Шаардлагатай зардлыг оролцогч талууд хариуцна.

(3) Оролцох хүсэлтэй орон нутгууд

Хятад : Хятад: Ляонин муж, Хубэй муж, Шаньдун муж, Жянсу муж

Хятад: Ляонин муж, Хубэй муж, Шаньдун муж, Жянсу муж

Япон: Хокайдо муж, Аомори муж, Акита муж, Ямагата муж, Нигата муж,

Ишикава муж, Фүкүй муж, Киото муж, Хёго муж, Тоттори муж, Шиманэ муж, Ямагүчи муж, Фүкүока муж, Сага муж, Нагасаки муж

Солонгос: Канвон муж, Чүнчоннам муж, Кёнсаннам муж

Орос: Приморийн хязгаар, Хабаровск хязгаар, Сахалин муж

* Хог хаягдлын судалгааны үйл ажиллагаанд NEAR-ийн гишүүн орон нутгуудаас гадна Зүүн хойд Азийн далайн эрэг орчмын орнуудын оролцоог дэмжиж, сурталчилна

(Зураг)



Далайн эрэг орчмын хог хаягдлыг судлах



Далайн хог хаягдлын сургалт



Хог хаягдлаар бүтээл хийж буй нь



Бүтээлийн үзэсгэлэн

【No.3 Зүүн хойд Азийн байгаль орчны сэдэвт зурагт хуудасны уралдаан】 Санаачилсан : Шаньси муж

1.Зорилго

Зүүн хойд Азийн бүсийн хүүхэд, залуучуудын дунд байгаль орчныг хамгаалах сэдэвт зурагт хуудасны уралдаан зохион байгуулж, шилдэг бүтээлээр үзэсгэлэн гаргаж, Зүүн хойд Азийн иргэдийн байгаль орчныг хамгаалах ухамсрыг нэг шат дээшлүүлэх

2. Төслийн агуулга

(1) Хугацаа : 2023 оны 10-11 сар

(2) Болох газар : Хятад, Шаньси муж

(3) Зохион байгуулах арга

- Орон нутгуудаас бага, дунд, ахлах сургуулийн сурагчдийн бүтээлүүдийг бүртгэж, шүүн шилдэг бүтээлийг шалгаруулна.

- Орон нутгуудаас шилдэг бүтээлүүдийг цахимжуулан Шаньси муж руу илгээнэ.

- ※ Ковид-19-өөс шалтгаалан бүтээлийг эх хувиар нь шуудангаар явуулах шаардлагагүй

- Шаньси муж нь орон нутгуудаас ирсэн бүтээлүүдийг хэвлэж, бүтээлүүдээр үзэсгэлэн гаргана.

(4) Жилийн төлөвлөгөө

3-6 сар : Уралдааны бүтээлүүдийг бүртэн цахимжуулна

10-11 сар : Зурагт хуудасны уралдаан, үзэсгэлэн зохион байгуулна

10 сар : Уралдааны дүн болон үзэсгэлэнгийн бүтээлүүдийг вэбсайтад байршуулна

3. Найдаж буй үр дүн

- Ард иргэдийн байгаль орчны талаарх ухамсар нэмэгдэнэ.
- Зүүн хойд Азийн байгаль орчны асуудлын талаарх мэдлэг, нийтлэг ухамсрыг нэмэгдүүлнэ

4. Орон нутгуудаас ямар байдлаар оролцох

(1) Орон нутгуудаас дараах байдлаар оролцоно

- Орон нутгуудаас уралдааны бүтээлүүдийг бүртгэж, шалгаруулна

- Шилдэг бүтээл (бүтээлийн нэр, бүтээлийн тайлбарын хамт) -ийг цахимжуулан зохион байгуулагч орон нутаг руу илгээнэ((хэрэв 2023 оны бүтээлийг илгээхэд хугацаа хүрэлцэхгүй байвал 2022 оны бүтээлийг илгээж болно)

- Шалгарсан бүтээлийг цахимаар Номхон далайн баруун хойд бүсийн байгаль орчны хамтын ажиллагааны төв /NPEC/- рүү илгээх

Жич: Хүлээн авагч орон нутгийн анхаарах зүйлс

- Орон нутгуудын мэдэгдэл, шалгарсан бүтээлийг илгээх хүсэлт

- Хүлээн авагч орон нутгийн хүрээнд бүтээлийг шалгаруулна
- Оролцогч орон нутгаас илгээсэн шалгарсан бүтээлийг хэвлэж, зургийн үзэсгэлэн зохион байгуулж, сурталчлах

(2) Зардал

Зардлыг дараах байдлаар гаргана

- Зургийн үзэсгэлэн, олон нийтэд сурталчлах арга хэмжээ болон нийт зардлыг зохион байгуулагч орон нутаг хариуцна.
- Оролцогч орон нутгууд бүтээлүүдийг сонгон шалгаруулах, бүтээлийг хүлээн авагчид
- илгээх зардлыг хариуцна.

(3) Оролцох орон нутаг

NEAR Холбооны нийт гишүүн орон нутаг

【No.4 Далайн эргийн амьд биетийн судалгаа】 Санаачилсан : Тояама муж

1.Зорилго

Зүүн хойд Азийн бүс далайн биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд тухайн бүс нутагт амьдардаг амьд организмын талаарх мэдээлэл цуглуулж, индикатораар амьдрах орчныг судална. Энэхүү судалгааг явуулснаар залуучуудын далайн амьтадын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, байгаль орчноо хамгаалах, биологийн олон янз байдлын талаарх ойлголтыг өгнө.

2. Агуулга

(1) Хугацаа : Жилд 1 удаа

(2) Болох газар : Оролцогч орон нутгийн далайн эрэг (Олон амьтад амьдардаг, чулуулаг, хайрганы талбай)

(3) Зохион байгуулах арга

- NPEC байгууллагаас гаргасан судалгаа хийх зааварчилгын дагуу судалгааг явуулж, үр дүнг бусад орон нутгуудтай хуваалцах

- Далайн амьд биетийнталаарх мэдлэгтэй судалгааны баг, ТББ, ашгийн бус байг ууллага, далайн амьдралын судлаачид болон бусад олон нийтийн оролцоотойг оор далайн амьтадыг судлан зураг, нэр төрлөөр нь бүртгэх
- Дэлхийн дулаарал эсвэл гаднын биеттэй холбоотой амьд организм байгаа эсэх ийг тодорхойлох
- Судалгааны үр дүнг Номхон далайн баруун хойд бүсийн байгаль орчны хамтын ажиллагааны төв /NPEC/ нэгтгэж, вэбсайт дээрээ байршуулна

(4) Жилийн төлөвлөгөө

6-7 сар : Оролцогчдыг бүртгэнэ

7-8 сар : Судалгааг явуулна

11 сар : Тояама муж руу судалгааны тайланг явуулна

3.Найдаж буй үр зүн

- Зүүх хойд Азийн далайн амьтадын суурьшилт, тархалтын талаар ойлголттой болох
- Далайн гадна амьдардаг амьд организмын амьдрах орчныг тодорхойлох
- Далайн биологийн олон янз байдал, түүнийг хамгаалах ухамсрыг төлөвшүүлэх

4.Орон нутгуудаас ямар байдлаар оролцох

(1) Орон нутгуудаас дараах байдлаар оролцоно

- Судалгааг явуулах судалгааны байгууллага, NGO/NPO төрийн бус байгууллага, мэргэжилтнийг сонгоно
- Судалгааны байгууллагуудтай хамтран судалгаа явуулж, үр дүнг нэгтгэж, тайлагнах

(2) Зардал

Зардал гарахгүй(Зардал гаргахгүйгээр зохион байгуулна)

(3) Хамрах хүрээ

NEAR-ийн гишүүн орон нутгуудаас далайтай орон нутгууд

【No.5 Хүүхэд залуучуудад зориулсан цэнхэр нүүрстөрөгч, нялцгай биет, байгаль орчны сургалт танин мэдэхүйн хөтөлбөр】 Санаачилсан : Чүнчоннам муж

1. Зорилго

Өсвөр насныханд далайн эргийн байгаль орчны боловсролоор дамжуулан далайн эргийн эко систем, цэнхэр нүүрстөрөгчийн ач холбогдлыг ойлгуулж, далайн эрэг орчмын эко системийг хамгаалах нь чухал болохыг сануулан байгаль орчны боловсролыг дэмжих

2. Агуулга

- (1) Хугацаа : 2023 оны 6 сараас хойш
- (2) Болох газар : Төсөлд оролцох орон нутгуудын далайн эрэг
- (3) Зохион байгуулах арга

① Залуу хясааг бойжуулж томорсны

дараа өсөлтийг нь хэмжиж,
(өсгөх үе, томрох үе, түүх үе)
нүүрстөрөгчийн хэмжээг судална

② Хясаа томортол усан дахь нүүрстөрөгч биед хуримтлагдах явцыг судална

< Жишээ >

- Хясааны ус цэвэршүүлэх үйл ажиллагаа судална

- Түүсэн хясаагаар хоол хийж иднэ (Нүүрстөрөгчийн эргэлт<Өсгөлт(үйлдвэрлэл)→Түүх(Агнах) → Хоол(Хэрэглээ)>-ны талаар судлах)

- Хясааны төрлийн музей үзэх (Хясаагаар дамжуулан цэнхэр нүүрстөрөгчийн ойлголттой болох)

- Цэнхэр нүүрстөрөгчийн талаарх сурах бичиг гаргаж тараах

③ Судалгааны тайлан

- (4) Жилийн төлөвлөгөө



далайд хясааг тавьжөөсгөж томруулсны дараа түүж буй нь



<Хясааг ашиглан ус цэвэршүүлэх туршилт>



<Түүсэн хясаагаар амттай хоол хийж идэв>



<Балар эртний чулуужсан хясаа(Цэнхэр нүүрстөрөгч) –г үзэх>

Орон нутгуудын нөхцөл байдлаас шалтгаалан нялцгай биетийг өсгөх үржүүлэх, загасны аж ахуй, нүүрстөрөгчийн тогтмол хэмжээ, байгаль орчны ангиллын судалгааг хийнэ. 2024 оны 1 сараас хойш гаргана.

3.Найдаж буй үр дүн

- Уур амьсгалын өөрчлөлт, далайн орчныг хамгаалах тухай ойлголтыг нэмэгдүүлэх
- Цэнхэр нүүрстөрөгчийн талаарх ойлголтыг дээшлүүлэх, байгаль орчны сургалтад цэнхэр нүүрстөрөгчийг идэвхтэй ашиглах
- Хясааны найрлага, агууламж зэрэгт анализ хийж нүүрстөрөгчийн гаралтыг багасгах бодлогыг боловсруулах (Чүнчоннам муж) -д үндсэн материал болгон ашиглана (мөн бусад орон нутгуудад лавлах материал болно)

4 Орон нутгуудаас ямар байдлаар оролцох

(1) Орон нутгууд дараах байдлаар оролцоно

- Оролцогч орон нутгаас хөтөлбөр төлөвлөгөө гаргах, оролцогчдыг хамруулах
- Хөтөлбөрийг явуулах
- Төслийн тайлан гаргах

(2) Зардал

Газар дээрх судалгааны зардал болон судалгаанд хэрэглэх хэрэгсэл авахад гарах зардлыг хариуцна

(3) Хамрах хүрээ

Далайд ойрхон NEAR-ийн зарим гишүүн орон нутаг

【No.6 “Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа сельфи зурагт” гэрэл зургийн уралдаан 1】 Санаачилсан : Томск муж

1 Зорилго

Байгаль орчноо хамгаалах сэдэвт гэрэл зургийн уралдааныг зохион байгуулснаар иргэдийг байгаль орчноо хамгаалах соёлд төлөвшүүлж, оролцоог идэвхжүүлэх.

2 Агуулга

(1) Хугацаа

2023 оны 4-12 сар

(2) Болох газар : Томск муж

(3) Зохион байгуулах арга

- ① Оролцогч орон нутгууд байгаль орчноо хамгаалах сэдэвт гэрэл зургийг бүртгэн хүлээж авна
 - Байгаль орчныг хамгаалах тухай гэрэл зураг
 - Мод тарьж суулгаж байгаа эсхүл цэвэрлэгээг харуулсан зураг (before & after) , ус нь цэвэрхэн орчныг харуулсан гэрэл зураг гм
 - Гэрэл зурагт тавигдах шаардлага
 - JPG,JPEG формат, цахимаар илгээх (зөвхөн сэлфи зураг)
 - ▬ Гэрэл зурагт хүрээ нэмэх, дүрсийг засварлах, компьютер ашиглан эвлүүлэг хийсэн бол тооцохгүй.
 - Оролцох хүрээ/ангилал
 - Сургуулийн өмнөх насны хүүхэд(асран хамгаалагчийн хамт зураг авахуулсан байх)
 - хүүхэд ▪ сурагч (бага, дунд, ахлах сургууль)
 - оюутан (их дээд сургууль, коллеж)
 - иргэд
- ② Орон нутгууд уралдаанд ирсэн гэрэл зургуудыг Томск муж болон NPEC руу илгээнэ
- ③ Томск мужаас гэрэл байгаль орчныг хамгаалах гол санаа, агуулга гэх мэтийг үнэлж шалгаруулна
- ④ Томск мужаас шилдэг гэрэл зургуудыг шалгаруулж, шалгарсан оролцогчдод болон бусад бүх оролцогчдод гэрчилгээ, гарын бэлгийг тухайн оролцогчийн орон нутгийн захиргаа руу илгээнэ
- ⑤ Оролцогч орон нутгууд- гэрчилгээ болон гарын бэлгийг гэрэл зургийн уралдаанд оролцсон хүмүүст илгээх.
- ⑥ Томск муж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан шилдэг бүтээлүүдийг танилцуулна.

(4) Жилийн төлөвлөгөө

4-10 сар : Оролцогч орон нутгуудаас явуулсан бүтээлийг Томск муж хүлээж

авах

11 сар Томск мужаас гэрэл зургийг шалгаруулна

12 сар Томск мужаас оролцогч орон нутгууд руу гэрэл зургийн уралдааны дүнг илгээж, SNS дээр шалгарсан бүтээлүүдийг нийтлэх

3 Найдаж буй үр дүн

Байгаль хамгаалах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

4 Орон нутгуудаас ямар байдлаар оролцох

(1) Дараах байдлаар оролцоно

Оролцогчдын бүтээлийг орон нутгийн хүрээнд шалгаруулж, Томск муж руу шалгарсан бүтээлүүдийг /и-мэйл/ илгээх.

(2) Зардал

Зардлыг зардлыг тухайн орон нутаг гаргана

- Орон нутгийн хэмжээнд уралдааны бүтээлүүдийг бүртгэж хүлээж авахад гарах зардал
- Оролцогч орон нутагт ирсэн шалгарсан бүтээлийн шагналыг шагналын эзэнд нь явуулах

(3) Оролцох хүрээ

NEAR-ийн нийт гишүүн орон нутаг

**【No.7 Зүүн хойд Азийн бүсийн амьд биетийн улирлын судалгаа Санаачилсан :
Тояама муж**

1 Зорилго

Интоорын мод цэцэглэх, соно харагдаж эхлэх зэргээс уур амьсгал, хүрээлэн буй орчны өөрчлөлтийг харж болох бөгөөд “биологийн улирал”-ын явцад нүүрстөрөгчөөс ангижрах тухай сургалт, судалгаа зохион байгуулах.

2 Агуулга

(1) Хугацаа : Жилд хэдэн удаа

(2) Болох газар

Орон нутгуудад

(3) Зохион байгуулах арга

- Тояама мужаас бэлтгэсэн гарын авлага дээр тулгуурлан орон нутаг бүрийн бага, дунд, ахлах сургууль, хувийн хэвшлийн байгууллагууд болон бусад хүмүүсийг оролцуулан судалгаа явуулсан.
- Судалгаанд тааруулан дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, бодлогын талаар сургалт явуулах
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөний эсрэг арга хэмжээ авах тухай сургалт зохион байгуулах
- Судалгааны үр дүнг Тояама муж (NPEC) нарийвчлан гаргана
- 2023 оны 6-р сард “Хөтлөгч (зохицуулагч)” -ийн сургалтыг орон нутгуудын төрийн албан хаагчдын дунд зохион байгуулахаар төлөвлөж байна. Амьд биетийн улирлын судалгааны ач холбогдол, зөв судалгаа явуулах арга зэргийн талаар тайлбарлаж, орон нутгууд төсөл үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд боловсон хүчнийг бэлтгэнэ.
- 2024 оны 2-р сард Зүүн хойд Азийн иргэдэд зориулсан “Зүүн хойд Азийн биологийн болон улирлын судалгааг дэмжих симпозиум” (цаашид симпозиум гэх) зохион байгуулахаар төлөвлөж байна. Дэлхийн дулаарлын нөхцөл байдал урьдчилан таамаглал, амьд организмд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэж, организмд хийх биологийн болон улирлын судалгааны арга замыг тайлбарлах.

(4) Жилийн төлөвлөгөө

4 сар : 【Тояама муж】 Семинарын агуулгыг гаргах

5 сар : 【Орон нутгууд】 Семинарт оролцогчдыг бүртгэх

6 сар : 【Тояама муж】 Семинар зохион байгуулах (Орон нутгууд оролцох)

4 ~ 5 сар : 【Орон нутгууд】 Судалгаанд оролцогч байгууллага,

оролцогчыг бүртгэх

- 4~12 сар : 【Орон нутгууд】 Судалгааг явуулах
- 12 сар : 【Орон нутгууд】 Тояама мужаас үр дүнг тайлагнана
- 1 сар : 【Тояама муж】 Симпозиум зохион байгуулах тухай танилцуулга
- 2 сар : 【Тояама муж】 Симпозиум зохион байгуулна (Орон нутгууд)

3 Найдаж буй үр дүн

- Иргэдийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээ, амьд биетийн ол он янз байдлын талаарх ухамсрыг төлөвшүүлэх
- Байгаль орчныг хамгаалахтай холбоотой иргэдийн түвшний эко амьдрарлыг идэвхжүүлэх

4 Орон нутгуудаас ямар байдлаар оролцох

(1) Орон нутгууд дараах байдлаар оролцоно

- Судалгаа явуулах газрыг сонгоно
- Судалгаанд тааруулан уур амьсгалын өөрчлөлт, нөлөөний эсрэг хариу арга хэмжээ авах талаар сургалт явуулах ТББ-ыг хамруулах
- Судалгаа, сургалт явуулах байгууллагад зааж зөвлөнө, судагаа, сургалтыг явуулна
- Судалгааны үр дүн(судалгаа·сургалт зохион байгуулах, даалгавар өгөх гм)-г Тояама мужид тайлагнах

(2) Зардал

- Шаардлагатай зардлыг тухайн оролцогч орон нутгаас хариуцна.

(3) Хамрах хүрээ

NEAR-ийн нийт гишүүн орон нутаг

【No.8 【Шинэ】 Гол мөрөнд био мониторинг хийх】 Санаачилсан : Приморийн хязгаар

1 Зорилго

Зүүн хойд Азийн гол мөрний усны чанарт дүгнэлт хийхийн зэрэгцээ байгаль орчны боловсрол олгохын тулд бага, дунд, ахлах ангийн сурагчдийг сайн дурын үйл ажиллагаанд оролцуулан Зүүн хойд Азийн бүсийн усны нийтлэг чанарт био

мониторинг үнэлт хийх аргыг боловсруулна.

2 Агуулга

(1) Хугацаа

2023 оны 9 сар (Жил бүр зохион байгуулна)

(2) Болох газар

Зүүн хойд Азийн орон нутгуудын цэнгэг уст газар

(3) Зохион байгуулах арга

•Цэнгэг усны чанарт шуурхай мониторинг хийх гэдэг нь үзүүлэлт болж буй амьд биетийг ажиглахыг хэлнэ. Тийм учраас бохирдолд тэсвэртэй чанар нь өөр өөр гол амьд биетийн үзүүлэлтийн мэдээллийг багтаасан тусгай гарын авлагыг Приморийн хязгаараас гарган тараах болно.

•Тараасан зааварчилгын дагуу орон нутгууд цэнгэг усны чанарт био мониторинг хийнэ

※ Үзүүлэлт болж буй цэнгэг усны тархалт нь Оросын Алс Дорнодын өмнөд хэсгээс Зүүн хойд Азийн улс орнууд хүртэл өргөн хүрээнд хамруулж үзэж байна. Гагцхүү нийтлэг үзүүлэлт бүхий амьд биет цөөхөн тохиолдолд тухайн орон нутагт тохирох амьд биетийн төрлийг онцолж сонгож болно. Гарын авлагыг Монгол, Орос, Солонгос, Хятад, Япон, Вьетнамд ч тохирохоор гаргахыг зорилго болгоно.

(4) Жилийн төлөвлөгөө

1-3 сар **【Приморийн хязгаар】** Цэнгэг усны чанарт био мониторинг хийх гарын авлага гаргана

4-5 сар **【NEAR-ийн Хэрэг эрхлэх газар】** Гарын авлагыг хэл бүрээр орчуулна

5-6 сар Гарын авлагыг орон нутгуудад тараана

7-8 сар **【Орон нутгууд】** Цэнгэг усанд био мониторинг хийх бэлтгэлийг хангана

9 сар **【Орон нутгууд】** Цэнгэг усанд био мониторинг хийнэ

9-10 сар **【Орон нутгууд】** Мониторингийн үр дүнг гаргана

11-12 сар **【Приморийн хязгаар】** Үр дүнг үнэлнэ, эцсийн тайланг гаргана

12 сар 【Приморийн хязгаар】 Мониторингийн үр дүнгийн талаар семинар зохион байгуулж, тайланг вэбсайтад бабйршуулна

3 Найдаж буй үр дүн

- Мониторинг хийхээр сонгосон гол мөрний усны чанарын төлөв байдлыг үнэлгээ хийх болон нэмж бохирдохоос урьдчилан сэргийлнэ
- Биологийн ухааны мэдлэгтэй болох, байгал орчны талаарх сонирхлыг нэмэгдүүлнэ

э

- Зүүн хойд Азийн бүсийн цэнгэг усны нийтлэг био үнэлгээг гаргана

4 Орон нутгуудаас ямар байдлаар оролцох

(1) Орон нутгууд дараах байдлаар оролцоно

- Уг судалгааг явуулах судалгааны байгууллага, ТББ, мэргэжилтнийг сонгоно
- Судалгаа шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран судалгаа явуулах, гарсан үр дүнг нэгтгэх, судалгаа явуулдаг хувийн байгууллагуудад заавар өгөх, сургалт явуулах
- Хэрэгжилтийн үр дүн (Мониторингийн үр дүн гм) Приморийн хязгаарт тайлагана
-

(2) Зардал

- Судалгаа явуулах, үр дүнг тайлагнах зэрэгт гарах зардлыг тухайн төсөлд оролцогч орон нутгууд хариуцна.

(3) Оролцох хүрээ

NEAR-ийн нийт гишүүн орон нутаг

iii Төсөлд оролцох хүсэлтэй орон нутаг

(◎ : Төслийг санаачлагч орон нутаг ○ : Төсөлд оролцох хүсэлтэй орон нутаг)

Орон нутаг ^{※1}	Төсөл	Байгаль орчны үйл ажиллагааны манлайлагч	Хог хаягдал ^{※2}	Зурагт хуудасны үзэсгэлэн	Далайн эргийн амьд биетийн судалгаа	Цэнхэр нүүрс төрөгч	Гэрэл зургийн уралдаан	Амьд биетийг улирлын судалгаа	Голусны мониторинг

Хятад	Шаньси муж	○	—	◎	—	—	○	—	—
	<u>Ляонин муж</u>	◎	—	—	—	—	—	—	—
Япон	Ямагата муж	○	○S	—	—	—	—	—	—
	Тояама муж	○	◎	○	◎	○	○	◎	○
	Ишикава муж	—	○S	—	—	—	—	—	—
	Фүкүй муж	—	○S	—	—	—	—	—	—
	Киото муж	—	○S	—	—	—	—	—	—
	Хёго муж	—	○S	—	—	—	—	—	—
	Тоттори муж	—	○S	—	○	—	—	—	—
	Шиманэ муж	—	○S	—	—	—	—	—	—
	Ямагүчи муж	—	○S	—	—	—	—	—	—
	<u>Сага муж</u>	—	○S	—	—	—	—	—	—
<u>Нагасаки муж</u>	—	○S	—	—	—	—	—	—	
Соло нгос	Ганвон муж	○	○S	—	—	—	—	—	—
	Чүнчоннам муж	○	○	○	○	◎	—	○	—
	Гёнсаннам муж	—	○S	—	○	—	—	—	—
Монгол	Дундговь аймаг	○	—	○	—	—	○	—	—
	Орхон аймаг	○	—	○	—	—	○	—	—

Орос	Алтайн хязгаар	○	—	○	—	—	○	—	—
	Приморийн хязгаар	○	○	○	○	○	○	○	◎
	Хабаровск хязгаар	○	○	○	○	○	—	○	○
	Томск муж	○	—	○	—	—	◎	—	○
	Амур муж	—	—	○	—	—	○	—	—
	Эрхүү муж	—	—	—	—	—	○	—	—
	Сахалин муж	—	—	—	—	—	○	—	—
Оролцох хүсэлтэй орон нутаг (улс/ орон нутгийн тоо)		5 улс, 12 орон нутаг	3 улс, 16 орон нутаг	5 улс, 10 орон нутаг	3 улс, 6 орон нутаг	3 улс, 4 орон нутаг	4 улс, 10 орон нутаг	3 улс, 4 орон нутаг	2 улс, 4 орон нутаг

※ 1 Зураас тэмдэглэгээ : ЗХАНЗХNEAR) -ны гишүүн бус орон нутаг

※ 2 ○ S : Хог хаягдлаар бүтээл хийхгүй, зөвхөн хог хаягдлын судалгаа явуулна

III Хорооны дараагийн зохицуулагч болох тухай санал асуулгын дүн

2021 оны 7 сараас Тояама мужаас NEAR-ийн Байгаль орчны хорооны хурлын зохицуулагчаар ажиллаж ирсэн бөгөөд зохицуулагчаар ажиллах хугацаа нь 2023 оны 7 сард дуусгавар болох юм. Үүнтэй холбогдуулан тус хорооны дараагийн зохицуулагчаар ажиллах хүсэлтэй орон нутаг байгаа эсэх талаар судлахын тулд санал асуулга явуулсан бөгөөд зөвхөн Тояама мужаас л дараагийн зохицуулагчаар ажиллах хүсэлтэйгээ илэрхийлсэн

IV Байгаль орчны хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө (2023 он)

Хугацаа	агуулга
Хэрэгжилт	○ Төслийг санаачилсан орон нутаг, төсөлд оролцох хүсэлтэй орон нутаг хооронд төсөл хэрэгжүүлэх талаар зөвшилцөнө ○ Зөвшилцөж тохиролцсон тохиолдолд тухайн нөхцөл байдалд тааруулан төслийг хэрэгжүүлнэ
8 сар~	○ Зохицуулагч орон нутаг 2023 оны төслийн хэрэгжилтийн байдал ба 2022 оны төслийн талаар судалгаа явуулж, үр дүнг нэгтгэнэ.
намар	○ Байгаль орчны хорооны 16-р хурал зохион байгуулна (Шиидэх асуудал) • Хорооны дараагийн зохицуулагч орон нутгийг сонгох

	<ul style="list-style-type: none"> • 2023 оны төслийн хэрэгжилтийн байдал • 2024 оны төслийн санал • Орон нутгууд байгаль орчны талаар мэдээлэл солилцоно
ӨВӨЛ	○ Зохицуулагч орон нутгаас 2024 оны төсөлд оролцох хүсэлтэй орон нутгийн судалгаа авч, судалгааны дүнг гаргана